

**СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**



Байгууллагын нэр: Архангай аймгийн Соёл урлагийн газар

Баталгаажуулсан:

Дарга

Захиргаа удирдлагын
хэлтсийн дарга

/Д.Аварзад /

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:

Мэргэжилтэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик
мэдээ хариуцсан мэргэжилтэн

/Т.Хонгорзул/

2024.06.25

БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Архангай аймгийн СУГ-н 2024 оны эхний хагас жилийн.....	3
үйл ажиллагааны үнэлгээний үр дүн	3
Архангай аймгийн СУГ-н 2024 эхний хагас жилийн үйл ажиллагаанд.....	3
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан	3
НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.....	3
ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	3
ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	4
3.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	4
3.2 БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	5
3.3 БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	5
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	6
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	6

**Архангай аймгийн СУГ-н 2024 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны үнэлгээний үр дүн**

Үзүүлэлт		Хувь
1	2	3
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	89
	3. Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	75
	4.Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	78,9
	5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	86,4
	6.Аймгийн засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлт	100
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	90
	2. Соёлын сайдын гэрээний биелэлт	88,4
	3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	80,4
	4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	90
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Явцын үнэлгээ	90,4
	2.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	97,3
	3. Шилэн дансны хөтлөлт	100
	4. Төсвийн хэмнэлт, үр ашигтай ажиллах талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээний тайлан	100
Ерөнхий үнэлгээ		90,4%

**Архангай аймгийн СУГ-н 2024 эхний хагас жилийн үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан**

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийг шийдвэр бодлого, төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт зохион байгуулалт хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, 2021 оны 374 дүгээр тогтоол, 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгов. Газрын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2024 оны эхний хагас жилийн байдлаар Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Аймгийн засаг даргын захирамжийг хэрэгжүүлэхээр хяналтад авсан 15 шийдвэр, 11 захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 100 хувийн үнэлгээ хийсэн байна.

Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Номын сангийн тухай, Музейн тухай хуулийг хэрэгжүүлэн 2024 оны эхний хагас жилийн байдлаар 18 соёлын төвөөс 82 удаагийн урлагийн тоглолт зохион байгуулж 16653 хүн хамрагдсан байна. орон нутаг судлах танхимаар 10 удаагийн үйлчилгээнд 1858 хүн, 9993 хүн номын сангийн үйлчилгээг авсан байна. Аймгийн хөгжимт драмын театр 12 удаагийн тоглолт зохион байгуулж 36676 хүнд үйлчилсэн байна. Аймгийн нийтийн номын сан 3 төрлийн үйлчилгээгээр 10790 хүнд номын сангийн үйлчилгээг үзүүлсэн бол музей 21 удаагийн арга хэмжээнд 4582 хүн хамруулсан байна. Засгийн газрын тогтоол шийдвэр, төсөв санхүүгийн сахилга батыг баримтлан, батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан.

3.1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Соёл урлагийн салбарын чиг үүрэгтэй холбоотой тусгагдсан хяналтад авсан 3 зорилт 8 арга хэмжээний хагас жилийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 89% хувьтай байна.

3.1.3 Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт

Соёл урлагийн салбарын чиг үүрэгтэй холбоотой тусгагдсан хяналтад авсан 1 зорилт 5 арга хэмжээний хагас гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 75% хувьтай байна.

3.1.3. Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн биелэлт:

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт газрын чиг үүрэгтэй холбоотой тусгагдсан 10 зорилтын 35 арга хэмжээний эхний хагас жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 78.9 хувьтай байна.

3.1.4 Архангай аймгийн 2024 оны жилийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт газрын чиг үүрэгтэй холбоотой тусгагдсан 3 зорилтын 18 арга хэмжээний эхний хагас жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 86,4 хувьтай байна.

3.1.5 Аймгийн засаг даргын захирамжийн биелэлт

2024 оны жилийн эцсийн байдлаар Засаг даргын 11 захирамж гарч биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 100 хувьтай байна.

3.2 БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.2.1 Соёлын сайд, Архангай аймгийн засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт

Сайдын гэрээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар дүгнэхэд 88.4 хувьтай байна.

3.2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 59 арга хэмжээнээс 6 арга хэмжээ удаашралтай явж байгаа тул гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулж 2 дугаар хагас жилд эрчимжүүлэхээр ажиллаж байна. Эдгээр арга хэмжээнээс “Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг нийт өрхийн дунд үе шаттайгаар зохион байгуулах”, “Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратеги боловсруулах” гэсэн 2 арга хэмжээний хэрэгжилт хоцорч явж байгаа тул эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна. Мөн 2024 оны 2 дугаар хагас жилд төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, ажлаа эрчимжүүлэх чиглэлээр дараах санал зөвлөмжийг өгч ажиллаж байна. Гүйцэтгэлийн биелэлт 80,4% байна.)

3.2.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

Байгууллагын нийт төсөв 370,4 мянган төгрөг батлагдсан. Үүнээс үндсэн цалин, нэмэгдэл цалин, урамшуулал, хоолны зардалд 287,8 мянган төгрөг буюу (77,6%), Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 6,0 сая төгрөг буюу (1,6%), унаа хоолны зардалд 19,0 мянган төгрөг буюу (5,1%) хувийн төсөв батлагдсан байна. Нэг албан хаагчид 1,0 төгрөгийн тэтгэмж олгосон. Томилт 5 албан хаагчид 2,0 төгрөг олгосон.

Соёл, урлагийн газрын дарга Төрийн албаны тусгай шалгалтаар чөлөөлөгдөж, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга тусгай шалгалтад тэнцэж томилогдсон. Захиргаа удирдлагын хэлтсийн даргын орон тоонд Төрийн албаны тусгай шалгалтаар Д.Аварзад томилогдсон. Соён гэгээрлийн мэргэжилтэн Ш.Гомбосүрэн Төрийн албаны тусгай шалгалтаар жинхлэн томилогдсон. Шилжилт хөдөлгөөн 8.3%

3.3 БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний хэрэгжилт:

Үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээнд 4 зорилтын 43 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжүүлэн жилийн эцсийн үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 96,2 хувьтай үнэлэгдлээ.

Байгууллагын ил тод байдлыг хангаж, иргэдэд хүргэх мэдээ мэдээллийг нэмэгдүүлэх, өөрийн үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Байгууллагын ил тод байдлыг сайжруулахад үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг цахим орчинд нэмэгдүүлэх чиглэл барьж ажиллав. 2023 оны жилийн эцсийн байдлаар цахим мэдээллийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна. “Архангай аймгийн Соёлын урлагийн газар” байгууллагын цахим пэйж хуудас, ar.mos.gov.mn вэб сайт болон байгууллагын мэдээллийн самбараар иргэдэд цаг тухай бүрд нь мэдээ, мэдээллийг хүргэж байна.

3.3.2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ:

2024 оны эхний хагас жилийн байдлаар www.shilendans.gov.mn хаягт төсөв санхүүгийн 6-н бүлгийн 27-н төрлийн 141 мэдээллийг бүрэн байршуулсан. Мөн Соёл урлагийн газрын даргын 14 тушаал шийдвэрийг цахим хуудсанд ил тод байршуулсан.

3.3.3 Төсвийн хэмнэлт, үр ашигтай ажиллах талаар зохион байгуулсан ажил арга хэмжээний тайлан

2024 оны 5 сарын байдлаар төсвийн гүйцэтгэл улсын төсвөөс 145,1 мян.төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс 139,7 мян төгрөгийн зарцуулалттай, 5,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Орон нутгийн санхүүжилт 05 сарын байдлаар 7,8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс 4,9 сая төгрөг буюу 63.2 хувийн гүйцэтгэлтэй. ОН санхүүжилтээс 05 сарын байдлаар гэрэл цахилгааны зардлаас – 1,5 сая төгрөг, цэвэр бохир усны зардлаас – 1,3 төгрөгийн хэмнэлттэй, түлш халаалтын зардлаас 2,4 сая төгрөгийн өглөгтэй байгаа.

ОН санхүүжилт нийт 7,8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс 4,9 сая төгрөгийн зарцуулалттай, 2,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй.

Нэмэлт санхүүжилт үйл ажиллагааны зардлаас УТ 55 сая төгрөгийн санхүүжилт, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 36,8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс 33,4 сая төгрөгийн зарцуулалттай, 3,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Нэмэлт санхүүжилтээр Төрийн захиргааны албан хаагчдын ОН нэмэгдэл 20 хувийн санхүүжилт 16,2 сая санхүүжилт хийгдсэнээс 12 сая төгрөгийн зарцуулалт хийж 4,2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй гарах зардал цалин хөлс 107,9 сая төгрөг зарцуулж нийт төсвийн 74.3 хувийг цалинд зарцуулж ажилласан. Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 63.2 хувийг зарцуулж орон нутгийн нийт төсвөөс 3.7 хувийн хэмнэлт үүссэн хангамж, бараа материалын зардалд нийт 7 сая төгрөгөөс 6,0 сая төгрөг зарцуулж 0,9 сая төгрөгийн хэмнэлт 85.9 хувийн гүйцэтгэлтэй үйл ажиллагаандаа зарцуулж ажилласан байна.

Байгууллагын хэмжээнд нийтийг хамарсан сургалт семинар, хурал зөвлөгөөн зохион байгуулаагүй байна. Шинээр ажлын чиг үүрэгт албан тушаал нэмэгдээгүй. Байгууллагын дотоод албан томилолтын зардалд 3,7 сая төгрөгийг 5 төрийн захиргааны албан хаагчдад олгосон. Зочид төлөөлөгч хүлээн авах,бэлэг дурсгалын зардал гараагүй байна.

Байгууллагын хувьд баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ой, уралдаан тэмцээн, аялал зугаалга зэргийг зохион байгуулаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Соёл урлагийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан зүйл, заалтуудын биелэлт, Соёл урлагийн газрын даргатай байгуулсан “2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хагас жилийн биелэлтийг үр дүнтэй зохион байгуулж ажилласан. 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ, үнэлгээний дундаж 90,4 хувьтай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Соёлын өв, соён гэгээрэл, урлаг уран бүтээлийн чиглэлээр 21 байгууллагаас хүлээн авч байгаа тайлангийн чанарыг сайжруулах төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа холбоог хангаж, статистик мэдээлэл, бодитой тооцоо судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөж, нэгтгэж тайлагнахад анхаарч ажиллах
- 2024 оны 2-р хагаст угийн бичиг хөтлөх өрхийн тоог нэмэгдүүлэх, аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратеги боловсруулах гэсэн 2 арга хэмжээний хэрэгжилтийг сумдад эрчимжүүлж ажиллахад анхаарах

